



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 626

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Усны газрын харьяа Сав газрын захиргаадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23 нэрийн нийт 16,088,258.00 (арван зургаан сая наян найман мянга хоёр зуун тавин найман) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Усны газрын дарга Ш.Мягмар, Сав газрын захиргаадын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 132006990

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
...6... дугаар тогтоолын хавсралт

**УСНЫ ГАЗРЫН ХАРЬЯА САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ЭЛЭГДЛЭЭРЭЭ АНХНЫ ӨРТГӨӨ НӨХСӨН АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1. БУЙР НУУР- МЭНЭНГИЙН ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА						
1	Мотоцикл	2020-12-31	ш	2	170,000.00	340,000.00
2	Компьютер Dell 3010	2013-11-14	ш	1	905,850.00	905,850.00
3	Зөөврийн компьютер Dell i7	2020-12-31	ш	1	150,000.00	150,000.00
4	Зөөврийн компьютер Dell 5421	2020-12-31	ш	1	90,000.00	90,000.00
5	Зургын аппарат	2020-12-31	ш	1	20,000.00	20,000.00
6	Өлгүүр	2020-12-31	ш	1	2,500.00	2,500.00
	Хэсгийн дүн					1,168,350.00
2.ХАР НУУР ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА						
7	Хэвлэх машин	2013-07-01	ш	1	470,000.00	470,000.00
8	Тог тохируулагч	2013-07-01	ш	2	43,900.00	87,800.00
9	Скайнер	2013-07-01	ш	1	95,000.00	95,000.00
10	Хувилах машин	2013-07-01	ш	1	1,799,900.00	1,799,900.00
11	Тог баригч	2013-07-01	ш	3	104,950.00	314,850.00
12	Зөөврийн комнютер	2013-07-01	ш	1	600,000.00	600,000.00
13	Зөвврийн комгнотер	2013-10-15	ш	1	941,930.00	941,930.00
14	Зөоврийн компьютер	2013-07-01	ш	1	1,722,000.00	1,722,000.00
15	Принтер SCX-4655 FN	2013-10-15	ш	2	382,470.00	764,940.00
16	Зургийн аппарат	2013-07-01	ш	3	249,380.00	748,140.00
17	Байршил тогтоогч GPS Garmen	2013-07-01	ш	2	323,064.00	646,128.00
18	Дуран	2013-10-15	ш	2	411,730.00	823,460.00
19	Байршил тогтоогч	2013-10-15	ш	2	622,710.00	1,245,420.00
20	Камер	2013-07-01	ш	1	611,310.00	611,310.00
21	Зөөврийн Компьютер DELL	2014-10-15	ш	1	1,581,470.00	1,581,470.00
	Хэсгийн дүн					12,452,348.00
3.ХӨВСГӨЛ НУУР-ЭГИЙН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА						
22	Мотоцикл Ли ван	2014-11-01	ш	1	1,698,000.00	1,698,000.00
23	Мотоцикл Shark 200	2015-08-10	ш	1	769,560.00	769,560.00
	Хэсгийн дүн					2,467,560.00
						16,088,258.00
	НИЙТ ДҮН					(арван зургаан сая наян найман мянга хоёр зуун тавин найман төгрөг)